



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 03-ны өдөр

№ А/12-Т

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын Хоёрдугаар бүлгийн 2.1, 2.3 дахь заалт, Гуравдугаар бүлэг болон “Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/09-Т тоот тогтоол, 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны 04 сарын 09-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар товлосон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссийн дарга /Р. Мөнхтөр/, Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.

“ИНВЕСКОР ББСБ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

